



БОГД БАНК
ИТГЭЛ ТҮГЭЭНЭ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Огноо: 2024.02.02

№ 24/12

Улаанбаатар хот

Богд Банк ХК-ийн гаргасан хувьцааны тодорхой хэсгийг буцаан худалдан авч халааслах тухай

Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.3, 36.11, 36.12, Компанийн тухай хуулийн 49 дүгээр зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.7, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Зөвшөөрлийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.3 дахь хэсэг, Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2021 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн А-262/262 тоот хамтарсан тушаалын хавсралтаар батлагдсан “Хувьцаат компани хэлбэртэй банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрлийн журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.2.6, 2 дугаар зүйлийн 2.6, СЗХ-ны даргын 2019 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн №38 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцааг худалдан авах санал гаргах, хувьцааг худалдан авах ажиллагааны журам”, Богд Банк ХК-ны дүрмийн 6 дугаар зүйл, 8 дугаар зүйлийн 8.14.13, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 2-р сарын 2-ны өдрийн ээлжит бус хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Богд банк ХК-аас олон нийтэд санал болгож гаргасан хувьцааны хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, эрэлт нийлүүлэлтийг тэнцвэржүүлэх, компанийн үнэлгээ болон хөрөнгө оруулагчийн эзэмшиж буй хөрөнгийн үнэ цэнийг өсгөх зорилгоор гаргасан хувьцааны 5%-иас хэтрэхгүй хэмжээний буюу энэхүү тогтоолын Хавсралт №1-д заасан тооцоолол, нөхцөлийн дагуу хувьцааг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтээс буцаан худалдан авсугай.
2. “Богд Банк” ХК-ийн нийтэд гаргасан хувьцааны тодорхой хэсгийг буцаан худалдан авах (халаасны хувьцаа) төслийг энэхүү тогтоолын Хавсралт №2-оор баталсугай.
3. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв, Хөрөнгийн биржтэй харилцах, холбогдох зөвшөөрөлийг авах, холбогдох бүртгэл тайлагналыг хийж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Г.Саруул)-д даалгасугай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавихыг Дотоод Аудитын Газар (Д.Төрмандах)-г тус тус даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.БОЛДХУЯГ

Богд Банк ХК-ийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн
2024 оны 8 сарын 2 өдрийн ээлжит бус хурлын
24/12. тоот шийдвэрийн Хавсралт-1



БОГД БАНК ХК-ийн ГАРГАСАН ХУВЬЦААНЫ ТОДОРХОЙ ХЭСГИЙГ БУЦААН ХУДАЛДАН АВАХ ТООЦООЛОЛ		
1.	Буцаан худалдан авах хувьцааны тоо ширхэг	62,500,000/ жаран хоёр сая таван зуун мянган ширхэг/
2.	Буцаан худалдан авах ханш /нэгж хувьцааны үнэ/	85 төгрөг
3.	Буцаан худалдан авах нийт үнийн дүн /төгрөг/	5,312,500,000
4.	Буцаан худалдан авах хугацаа	1 сар хүртэл